

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 4/19.

Арвайхээр

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг
“КОМИРНЭТИ” (BNT162b2) вакцинаар
дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг “Комирнэти” (BNT162b2) вакцинаар дархлаажуулах тухай” А/404 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдсэн Пфайзер-БиоН”Тех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) вакцинаар зааврын дагуу сайн дурын үндсэн дээр эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 12-15 насны хүүхдийг вакцинжуулах арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг “Комирнэти” (BNT162b2) вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар тус тус баталсугай.

3. Зорилтот насны хүүхдийг вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулах, мэргэжлийн удирдлаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа), хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас урьдчилан зөвшөөрөл авч вакцинжуулах, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, вакцинжуулсан хүн амыг бүртгэх, дархлаажуулалтын цахим бүртгэлийн программын хэвийн үйл ажиллагааг ханган, вакцин, дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 06 сарын 24 ны өдрийн
А.Н. дугаар тушаалын хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ "КОМИРНЭТИ"
(BNT162B2) ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

№	Сум, өрхийн эрүүл мэндийн нэр	Зорилтот бүлэг				Нийт хамрагдах хүүхэд	Шаардагдах тоо (2 удаагийн тун)				
		12 настай хүүхэд	13 настай хүүхэд	14 настай хүүхэд	15 настай хүүхэд		Вакцин		Тариур		Аюулгүй хайрцаг
							Нийт хүн тун	1 фл (6 хүн тун)	0.3 мл	2 мл	
1	Баруунбаян-Улаан	54	59	53	44	210	420	70	420	70	5
2	Бат-Өлзий	175	171	140	113	599	1198	200	1198	200	14
3	Баянгол	87	81	75	57	300	600	100	600	100	7
4	Баян-Өндөр	88	82	60	47	277	554	92	554	92	6
5	Богд	131	115	118	87	451	902	150	902	150	11
6	Бүрд	73	48	58	49	228	456	76	456	76	5
7	Гучин-Ус	54	37	32	30	153	306	51	306	51	4
8	Есөн-зүйл	58	54	59	52	223	446	74	446	74	5
9	Зүүнбаян-Улаан	72	80	56	60	268	536	89	536	89	6
10	Нарийнтээл	68	61	63	52	244	488	81	488	81	6
11	Өлзийт	46	61	47	38	192	384	64	384	64	4
12	Сант	76	78	70	61	285	570	95	570	95	7
13	Тарагт	62	54	41	44	201	402	67	402	67	5
14	Төгрөг	50	52	39	48	189	378	63	378	63	4
15	Уянга	178	185	181	175	719	1438	240	1438	240	17
16	Хайрхандулаан	59	66	59	49	233	466	78	466	78	5
17	Хархорин	245	238	198	179	860	1720	287	1720	287	20
18	Хужирт	157	139	122	101	519	1038	173	1038	173	12
19	нарны дөш	307	283	234	197	1021	2042	340	2042	340	24
20	Уян сэтгэл	220	176	159	151	706	1412	235	1412	235	16
21	Түшигдөлгөөн	235	178	158	173	744	1488	248	1488	248	17
	Нийт	2495	2298	2022	1807	8622	17244	2874	17244	2874	201